



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-16

1. Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлт	7-10
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	10-12
3. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	12-13
4. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал	13-15
5. “Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	15-16

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Сэддорж;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Батцэцэг, Х.Ганхуяг,
Д.Жаргалсайхан, Н.Наранбаатар, Ц.Туваан;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр.

Нэг.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Сонсголын тайлан болон санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын судалгааны тайланг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Бейсен ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар 10.1-д заасны дагуу

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачилсан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар нарыг дэмжсэнээр тооцож, 68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, У.Отгонбаяр, А.Ундраа нарыг дэмжсэнээр тооцож, 68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарыг дэмжсэнээр тооцож, 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Н.Алтаншагай, С.Замира, П.Батчимэг нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр өнөөдөр 17 цагт Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг наашлуулж энэ хурлаараа хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 6

Бүгд: 20

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудал болон “Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов.

Дөрөв.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хуралд дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга У.Отгонбаяр Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийг нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Байнгын хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нэрээ татаж байгаа тухай мэдэгдэж, үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хуралд дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга У.Отгонбаяр Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайг нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 5

Бүгд: 21

76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Тав.“Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын бэлтгэх хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийг нэмж оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 46 минут үргэлжилж, 29 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 68.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 33 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүн сонгосон тойрог, нэрээр танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Одонтужаа гишүүн, Лүндэг гишүүн нар ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

1.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг нь дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага Төрийн удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих үнэлэгч сэдэвт ерөнхий хяналтын сонсголон тайлан сонсох, санал, дүгнэлтийг сонсох.

2.Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл, Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд

хяналт тавих үнэлэх сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын санал, дүгнэлтийг хэлэлцье.

Монгол Улсын Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 21 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдвээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсний дагуу сонсголын 2026 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдөр зохион байгуулсан.

Дээрх сонсголын тайлан, санал, дүгнэлтийг сонсгол даргалагч Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгуур нүүдлийн соёл иргэншил, уламжлалт, мал аж ахуйн салбар, малчдыг дэмжих үүднээс Малчдын тухай анхдагч хуулийн төслийг санаачлан өргөн барьж Улсын Их Хурлаар 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлуулж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тус хууль хэрэгжиж эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлын гишүүд орон нутагт ажиллах үеэр Малчны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй нөхцөл байдалтай байгаа талаар малчид, иргэдээс нэлээдгүй санал гарч байсан тул Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, О.Алтангэрэл, О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганбаатар, Д.Ганбат, М.Ганхүлэг, Б.Заяабал, С.Лүндэг, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Ц.Туваан, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа, Г.Хосбаяр, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Р.Эрдэнэбүрэн нарын 21 гишүүнээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.12, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалтыг үндэслэн энэ хуулийн хэрэгжилтийн байдлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр гаргасан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т “Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын Ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулна” гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” 05 дугаар тогтоолоор “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ томилогдсон.

Мөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор уг сонсголын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн

Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, Л.Мөнхбаясгалан, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Ц.Туваан, Г.Тэмүүлэн нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд:

1.“Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголын зарыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “...сонсгол явуулах сэдэв, огноо, оролцогч, ажиглагчийг бүртгэх зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулна...” гэж заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр www.parliament.mn цахим хуудаст байршуулсан.

2026.05.27-ны өдөр Сонсгол санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ерөнхий хяналтын сонсгол даргалагч, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар сонсголын зохион байгуулалттай холбоотой асуудлаар хэвлэлд ярилцлага хийж, олон нийтэд мэдээлсэн. 2026.06.17-ны өдөр ажлын хэсгийн гишүүд “Их хуралдай” танхимын дэргэд хэвлэлийн бага хурал хийсэн.

Оролцогчдыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121.11-д заасны дагуу “...14-өөс доошгүй хоногийн хугацаанд бүртгэнэ...” гэж заасны дагуу 06 дугаар сарын 18-ны өдрийн 17.00 цаг хүртэл бүртгэлээ.

Ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг 2026 оны 06 сарын 04, 10, 17, 30-ны өдрүүдэд 4 удаа хуралдсан.

2.“Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сонсголыг зохион байгуулах хүрээнд ажлын хэсгийн гишүүд холбогдох 19 төрийн байгууллагуудаас баримт бичиг гаргуулан авч Монголын хуульчдын холбооны судлаачаар Малчны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан, зарим төрийн байгууллагуудын мэдээллийг сонссон.

Ерөнхий хяналтын сонсголын талаар:

“Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын 06 дугаар сарын 23-ны эхний өдөр Байнгын хорооны гишүүдийн ирц 51.7 хувийн ирцтэй 09 цаг 34 минутад эхэлж хуралдсан бол 06 дугаар сарын 24-ний сонсголд Байнгын хорооны гишүүдийн ирц 65.5 хувьтай бүрдсэнээр сонсгол эхэлж, нийт төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын төлөөллөөс давхардсан тоогоор 163 оролцогч оролцсон байна.

Сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад

асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу МҮОНРТ-ээр, “Малчин” телевизээр, хэл яриа сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулж бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-т заасны дагуу сонсголд оролцож санал хэлэхээр хүсэлт гарган бүртгүүлсэн цахим хуудсаар саналаа ирүүлсэн 6 иргэн, заалнаас давхардсан тоогоор нийт 40 гаруй иргэн санал бодлоо илэрхийлж, тайлбар, үг хэлэв.

Нэгдсэн дүгнэлт

Хоёр өдрийн сонсголын мэдээлэл, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, төрийн байгууллага, албан тушаалтны тайлбар, танилцуулга, иргэдийн санал, Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үндэслэн дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1. Малчны тухай хууль батлагдсанаас хойш жил гаруй хугацаа өнгөрсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Хуульд заасан зарим чухал хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, журам батлагдаагүй, салбар дундын ажлын уялдаа хангалтгүй, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих тогтолцоо сул байна.
2. Малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, залгамж халааг бэлтгэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалтууд бодит үр дүнд хүрээгүй. Ялангуяа малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалт, малчны хөгжлийг дэмжих зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.
3. Малчдын өмнө тулгамдсан хамгийн том асуудал нь бэлчээр, газрын харилцаа, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл хэвээр байна. Малчдын бэлчээр ашиглах эрх, өвөлжөө, хаваржааны хамгаалалт, усны нөөцийн ашиглалттай холбоотой зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай байна.
4. Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үнэлэмж, малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Малчид хамгийн найдвартай зээлдэгч хэдий ч өндөр хүүтэй зээл авч байгаа нь хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт, ипотека, даатгалын тогтолцооны хүртээмж сул байгааг харуулж байна.
5. Малчны тухай хууль нь зөвхөн нэг салбарын бус, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үндэс, хүнсний аюулгүй байдал, үндэсний уламжлалт мал аж ахуй, хөдөөгийн хөгжлийн суурь асуудлыг зохицуулсан бодлогын ач холбогдолтой хууль болохыг онцлон тэмдэглэв.

Цаашид авах арга хэмжээний талаар

Малчны эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр:

Малчны зээлийн бодлогыг шинэчилж эрсдэлд суурилсан хүү, төлбөрийн түүх, индексжүүлсэн даатгал, тогтвортой худалдан авагчтай эсэх зэрэг шалгуур үзүүлэлтийг ашиглах боломжийг судлах.

Малчны хөрөнгийн үнэлгээний тогтолцоо, хөрөнгийн үнэлгээний аргачлалыг боловсруулж мөрдүүлэх.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг удаагийн нөхөн төлөлтийн асуудлыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх.

Малчдын эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхдийн дотуур байр, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх салбар дундын уялдааг хангаж, арга хэмжээг эрчимжүүлэх.

Малчны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Малчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх, тэдний залуу халааг бэлдэх асууд дээр анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

“Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдвээр Ерөнхий хяналтын сонсголын тайлан, санал, дүгнэлтэд үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Сонсголын тайлан, санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж үг хэлэх гишүүд байна уу нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Отгонбаяр гишүүн. Отгонбаяр гишүүний микрофон.

У.Отгонбаяр: Байнгын хорооны дарга гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе ээ.

Үдээс хойшийн хуралдаанаар чинь миний ойлгосноор бусад гэсэн асуудал байгаа гэж ойлгосон. Зөв биз дээ. Тэгээд ганц бусад гэсэн асуудал байгаа юм чинь тэрийг нааш нь татаад энэ одоогийнхоо хуралдаанаар хэлэлцээд явах тийм горимын санал гаргаж байна.

Б.Бейсен: Тэгэхээр түрүүн нөгөө хэлэлцэх асуудлыг баталсан. Дэгд нь ямар юу байдаг юм бол? Гишүүдээ Отгонбаяр гишүүний саналаар.

Уг нь би түрүүн асуусан шүү дээ. Саналтай гишүүн байна уу гээд.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуулийн 120.2-т заасан сонсголыг Байнгын хороо явуулсан бол сонсголын тайланг агуулгыг өөрчлөхгүйгээр Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусган нэгдсэн хуралдаанд

танилцуулж болно гэж заасны дагуу Малчны тухай хуулийн хэрэгжилт, дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах асуудлыг санал хураалтаар шийдвэрлэнэ.

Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх ерөнхий хяналтын сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120.6-д Байнгын хороо сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана гэж заасны дагуу Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу. Нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуулийн 120.6-д Байнгын хороо сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж заасны дагуу “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Ганбаатар гишүүн 2-ийг дэмжсэнээр аваарай.

Манай ажлын албаныхан Батчимэг гишүүнийг нэмж оруулъя.

Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, ерөнхий хяналтын сонсголын тайлан болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ерөнхий хяналтын сонсголын тайлан санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

10.52 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалд орёе.

Хоёр.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Хаана байна? Болорчулуун дарга ирэх ёстой байхгүй байна. Замд ирж байгаа юм байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед Улсын Их Хурлын зарим гишүүдээс уг хуулийн төсөл болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэгт заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол тухайн Байнгын хороо уг төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн байна гэснийг үндэслэн хуралдаан даргалагч Эдийн засгийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт буцаасан.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн.

Төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нараас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн тогтвортой хөдөө аж ахуй 12 дугаар зүйл, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилгоор Улсын хэмжээнд дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байхаар тусгаж өргөн мэдүүлсэн.

Дээрх зохицуулалттай нийлүүлж Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлтүүд, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах санал гаргасныг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр дэмжсэн болно оо.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед Улсын Их Хурлын гишүүд уг хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэгт заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай Байнгын хороо уг төслийг хэлэлцэж санал, дүгнэлт ээ холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн байна гэснийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн тул хуралдаан даргалагч уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт буцаасан.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.5 дахь хэсгийг баримтыг хэлэлцэж санал, дүгнэлт ээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд ирүүлсэн болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье.

Гишүүд та бүхэн тухайн хуулийн төсөлтэй холбоотой асуулт асууж болно.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнд микрофон өгье Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Нэгэнт гаргаж байгаа хуулийн төсөлтэй холбоотойгоор зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Дэгийн тухай хуулийнхаа дагуу одоогийн чуулганы хэлэлцүүлгээр анхны хэлэлцүүлгээр батлах ийм саналыг оруулж байгаа юм.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүний горимын саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасны дагуу Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдээрэй гишүүд.

Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

Отгонбаяр гишүүнийг дэмжсэнээр явъя. Ганхүлэг гишүүн. Ундраа гишүүн 3-ыг дэмжсэнээр аваарай. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна.

11.00 цаг

Дараагийн асуудалд оръё.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 18 гишүүнээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаарх хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн.

Өнөөдөр хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна. Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ганхүлэг, Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Замира Улсын Их Хурлын гишүүн, Мандхай Улсын Их Хурлын гишүүн, Одонтуяа Улсын Их Хурлын гишүүн, Отгонбаяр Улсын Их Хурлын гишүүн, Алтаншагай Улсын Их Хурлын гишүүн, Ундраа Улсын Их Хурлын гишүүн, Батчимэг гишүүн түрүүн санал гаргасан тиймээ. Батчимэг гишүүн Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтанд тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг М.Ганхүлэгт зөвшөөрсүгэй.

Батчимэг гишүүн орохгүй юм байна. Өөр юун дээр орох юм байна. Энэ тогтоолын төсөлд орохгүй юм байна. Тогтоолын төсөл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Тогтоолын төсөл 65 хувиар дэмжигдлээ.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүнийг дэмжсэнээр авъя.

Отгонбаяр гишүүн горимын санал гаргая.

У.Отгонбаяр: Байнгын хорооны дарга эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Би нэг горимын санал гаргах гээд байна. Үдээс хойшийн оройны байнгын хорооны 17 цагийн хуралдааны хэлэлцэх асуудлыг нааш нь татаад одоо энэ хуралдаанд хэлэлцэж шийдвэрлэх ийм горимын санал гаргаж байна.

Хоёр дахь нь Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах ийм 2 горимын санал гаргаж байна.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Отгонбаяр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувиар дэмжигдсэн тул хуралдааныг үргэлжлүүлэн явуулъя.

Дөрөв.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал

Бусад асуудлын хүрээнд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.

Байнгын хорооны даргад нэр дэвшигч Бат-Өлзийн Бат-Эрдэнийн танилцуулгыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Ухнаагийн Отгонбаяр танилцуулж байгаа. Уг асуудлаар Улсын Их Хурал дахь АН-аас завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байгаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргая гэж байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд МАН-ын бүлгээс дэмжиж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар миний нэрийг дэвшүүлсэн. Тэгээд Монгол Улсын парламентад эмэгтэйчүүд маань энэ удаагийн 126 гишүүнтэй парламентад олон тоо бүрдүүлж байгаа. Гэхдээ тодорхой Улсын Их Хурлын

бүтцийн байгууллагууд дээр эмэгтэйчүүдийн квотыг хангаж тодорхой хэмжээнд эмэгтэйчүүдээ оруулж ажиллах нь зүйтэй болов уу гэж бодож байгаа.

Тийм учраас би өөрийн нэрийг татаж байгаагаа албан ёсоор хэлмээр байна. Ингээд намын бүлгээс дахиад өөр нэр дэвшилт хийлгэхийг хүсэж байна. Отгонбаяр даргыг урьж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Нэр дэвшигч Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн нэрээ өөрөө татаж байгаа учраас Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх өөр саналтай гишүүд байна уу? Ардын намын бүлгийн дэд дарга Ухнаагийн Отгонбаяр нэр дэвшүүлэе.

У.Отгонбаяр: Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг нэр дэвшүүлж байна аа. Мэндбаярын Мандхай нь 1981 онд Улаанбаатар хотод төрсөн. Нөхөр хүүхдүүдийн хамт амьдардаг. 1998-2002 онд аялал жуулчлалын удирдлагын дээд сургуулийг Эко аялал жуулчлалын менежмент мэргэжлээр төгссөн. Бест Лондон коллеж, Их Британи, Лондон хот аялал жуулчлалын удирдлагаар диплом, 2007-2008 онд Их Британи дахь Америкийн олон Улсын Их сургууль, Лондон хот Бизнесийн удирдлагын магистр, 2023 оноос МУИС-ийн Улс төр судлал ОУХНУС-ийн докторант.

Ажилласан байдлыг танилцуулъя.

2006-2008 онд Англи улс дахь оффис хэрэглэгчийн зөвшөөрөл Комплайнс хариуцсан мэргэжилтэн, 2008-2009 онд Ази Номхон далайн хөрөнгө оруулалтын Партнерс ХХК-д маркетинг төслүүд хариуцсан менежер, 2009-2011 онд Нортекс ХХК Бизнес хөгжил хариуцсан захирал, 2011-2015 онд Оюу Толгой ХХК-д Нийгмийн төслүүд хариуцсан төслийн менежер, 2015-2016 онд Нүүдэлчин Групп ХХК группийн Бизнес, хөгжил хариуцсан захирал, 2016-2018 онд Монголжин стратегийн компанид зөвлөх, 2018-2021 онд Сүү ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2021-2023 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Бизнес ба хүний хөгжил төслийн үндэсний зөвлөх, 2023-2024 онд Социал демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны ЕНБД, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр тус тус ажиллаж байна.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс Мэндбаярын Мандхайн ажлын туршлага, мэдлэг ур чадварыг харгалзан үзсэний үндсэн дээр БОХХАА байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Бейсен: Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Байнгын хорооны дарга, нэр дэвшигчээс асуулт асуух гишүүд нэрс өгнө үү? Байхгүй байна. Үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Мэндбаярын Мандхайг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя

Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя.

76.2 хувиар нэр дэвшигч дэмжигдлээ.

Одонтуяа гишүүний микрофон өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр өнөөдөр Байнгын хороон дарга солигдож байгаа юм байна. Тэгээд өнгөрсөн 2 жилийн хугацаанд ажилласан Бейсен гишүүний талаар хэд хэдэн дүгнэлт хэлье гэж бодож байна. Тэгээд өнгөрсөн 2 жилийн хугацаанд манай Байнгын хороо олон чухал асуудлуудыг хэлэлцэж баталсан. Тэгээд ер нь манай Байнгын хороо шиг ийм ирц нь байнга хүрээд бүх асуудлуудаа маргаангүй ингэж баталсан Байнгын хороо цөөхөн юм шиг байна. Тэгээд Бейсен гишүүндээ баяр хүргэх гэсэн юм аа.

Ялангуяа сүүлд маш яаралтайгаар орж ирсэн Уур амьсгалын өөрчлөлтийн хууль дээр Байнгын хорооны даргын зүгээс сайн дэмжлэг үзүүлсний хүчинд энэ хууль их богино хугацаанд Копын өмнө батлагдлаа.

Тэгээд тусгай хамгаалалттай хуулийн өмнө, бусад хуулиудын өмнө бас Байнгын хорооны гишүүдийг гадаадад, дотоодод туршлага судлуулах энэ ажлуудыг нэлээд сайн хийж өгсөн олон чухал хэлэлцүүлгүүдийг манай Байнгын хороо хийлээ. Тэгээд Бейсен гишүүндээ баяр хүргэе. Бүгдээрээ нэг сайхан алга ташчих уу?

Тэгээд амжилт хүсье ээ. Тэгээд шинээр томилогдож байгаа Мандхай гишүүндээ амжилт хүсье. Эмэгтэйчүүд дарга болоод л байвал баярлаад л байна.

Б.Бейсен: Юуны өмнө Байнгын хорооны даргаар нэр дэвшээд сонгож байгаа Мэндбаярын Мандхай гишүүнд баяр хүргэе.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн бас жендерийн асуудлыг бодоод нэрээ татсанд баяр хүргэе. Өсөх ирээдүйтэй залуу гишүүн гэдгээ харуулж байна. Жендерийн мэдрэмжтэй ийм сайхан санал гаргалаа 1 дүгээрт.

2 жилийн хугацаанд хамтран ажилласан Байнгын хорооны гишүүд, ажлын албаныханд баярлалаа. 2 жилийн хугацаанд бид нар нэлээн олон хуулийн төслүүд хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа, хамтарч ажиллалаа. Ямар нэгэн хэл ам татлаа түлхлээ янз бүрийн юм гараагүй 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ асуудлыг чинь 6 сарын 6-нд би гадагшаа явах ёстой байсан бас Ардын намын бүлгийн дотоод зохион байгуулалттай холбоотой хойшлуулж өгөөч гээд хойшлуулсан. Тэгээд би энэ мөнгөн аяга, хадгаа бэлдээд 3 сар болж байгаа. Өнөөдөр тэгээд өгөх гээд эмчилгээндээ явах гэж байна. Тэгээд хамтарч ажилласан та бүхэнд баярлалаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна.

11.14 цаг

Тав. “Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх сэдэвт ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын гишүүн, Гомбын Ганбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Мөнгөнсүхийн Ганхүлэг гишүүн Их хурлын гишүүн, Сонгобайн Замира Монгол Улсын Их Хурлын гишүүн, Лувсанбямбын Мөнхбаясгалан Улсын Их Хурлын гишүүн, Ухнаагийн Отгонбаяр Улсын Их Хурлын гишүүн, Р.Сэдэددорж Монгол Улсын Их Хурлын гишүүн, Ц.Туваан Улсын Их Хурлын гишүүн.

Түрүүчийн нөгөө зарчмын зөрүүтэй саналын дагуу Батчимэг гишүүнийг энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулж байгаа. Энийг нэмж тусгая.

Тогтоолын төслийг түрүүн танилцуулчихсан учраас Батчимэг гишүүнийг тогтоолын төсөлд нэмж оруулъя.

Батчимэг гишүүнийг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя ажлын хэсэгт оруулахыг. Санал хураалтад бэлдээрэй гишүүд.

Санал хураалт.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд ажлын хэсгийнхэнд Баярлалаа.

11.16 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА